

ГАДААД ЭДИЙН ЗАСГААС ХАМААРАХ ХАМААРАЛ: МОНГОЛ УЛСЫН ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВЛӨРЛИЙГ ХЭМЖИХ НЬ

Б.Энх-Амгалан*

Хураангуй: Улс орон гадаад эдийн засагтай харилцахгүйгээр эдийн засгийн хөгжлөө түргэтгэх боломжгүй юм. Гадаад эдийн засгийн харилцааг тодорхойлдог гол үзүүлэлт нь экспорт, импорт, гадаад зээл буюу өр, ажиллах хүчний мөнгөн гуйвуулга, гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж үздэг.

Манай улс цар тахлыг харьцангуй хохирол багатай хурдан даван туулж хилээ эрт нээснээр гадаад худалдааны эрчмийг нэмэгдүүлж экспорт, импорт аль аль нь түүхэн дээд хэмжээнд хүртлээ өссөн. Гадаад мөнгөн гуйвуулга цар тахлаас хойш багассан бол гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад өрийн хэмжээ нэмэгджээ.

Энэ судалгааны ажилд гадаад эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг ашиглан төвлөрөл ямар түвшинд байгааг Herfindahl-Hirschman Index (HHI)-ээр тодорхойлон харууллаа.

Судалгааны үр дүнгээс харвал HHI нь 2023 оны байдлаар 3046 гарсан нь төвлөрөл хэт өндөр байна гэсэн үг юм. Цаашид гадаад эдийн засгийн харилцааг тодорхойлж байгаа эдгээр 5 үзүүлэлтийг эдийн засагт гүйцэтгэх үүргээр нь харгалзан жигд оролцоотой байлгахад анхаарах шаардлагатай байна.

Түлхүүр үгс: гадаад эдийн засгийн хамаарал, экспорт, импорт, ГШХО, мөнгөн гуйвуулга, гадаад өр, HHI.

FOREIGN ECONOMIC DEPENDENCE: MEASURING MONGOLIA'S FOREIGN ECONOMIC CONCENTRATION

Abstract: A country's economic development relies heavily on engaging in foreign economic relations. Key indicators determining these relations include exports, imports, foreign loans or debts, labor remittances, and foreign direct investment (FDI).

Despite the challenges posed by the epidemic, our country swiftly recovered and incurred relatively minor damages, allowing for an early reopening of borders. Consequently, foreign trade surged, marking historic highs in both exports and imports. Although labor remittances declined post-pandemic, foreign direct investment and foreign debt showed notable increases.

Research investigating the proportional contribution of these foreign economic indicators to overall foreign economic relations, and their impact on the economy, is sparse. This study employs the Herfindahl-Hirschman Index (HHI) to assess the concentration of these indicators.

As of 2023, the study reports an HHI of 3046, indicating an excessively high concentration. Moving forward, there is a critical need to foster more balanced participation among these five indicators, which fundamentally shape our foreign economic relations and influence our economy.

Keywords: foreign economic dependence, export, import, FDI, remittance, foreign debt, HHI.

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): enkhamgalan@num.edu.mn

Удиртгал

Тухайн нэг улсын эдийн засгийн хөгжил нь өөрийн улсын дотоод нөөц боломжоос гадна гадаад эдийн засгийн оролцоотой байж илүү түргэн хөгждөг. Улс орнууд хөгжлийн тодорхой шатанд гадаадын шууд болон багцын хөрөнгө оруулалтыг татах, гадаад худалдааг либералчлах, гадагш ажиллах хүчийг илгээх, шинэ техник, технологи, инновацыг нэвтрүүлэх, гаднаас мөнгөн гуйвуулга хүлээн авах, гадаад улсуудаас шаардлагатай зээл тусламжийг авах замаар эдийн засгийн хөгжлөө хурдасгаж өндөр өсөлтийг бий болгож ирсэн.

Монгол улсын хувьд 1911 онд тусгаар тогтнолоо зарласнаас хойш гадаад эдийн засгийн харилцаагаа гүнзгийрүүлж гадаад худалдааны гаалийн татвараар төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлэх, Хятад, Оросын хөрөнгө оруулагчдын тусламжтайгаар банк байгуулах, засгийн газрын зүгээс гадаадын хөрөнгө оруулалттай Монголоор алтны уурхайг байгуулах зөвшөөрөл олгож татвар авах, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийн тулд Орос улсаас зээл авах зэргээр эдийн засагт дэмжлэг болох арга хэмжээнүүдийг авч байсан талаар Сангийн яамны Түүхэн замналд дурджээ.

Үүнээс хойших хугацаанд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцааны үед социалист системийн улс орнуудтай гадаад эдийн засгийн өргөн харилцаатай байсан бөгөөд худалдаа, хөрөнгө оруулалт, зээл тусламжийн гол түнш нь ЗХУ байв. Энэ үе үндсэндээ 1990 он хүртэл үргэлжилсэн.

Зах зээлийн чөлөөт эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990 оноос хойш Монгол улсын эдийн засгийн бүтэц бүрэн өөрчлөгдөж өөрөө өөрийгөө авч явах шаардлага гарсан бөгөөд шилжилтийн хүнд үеүдэд олон улсын зээл тусламж нь эдийн засагт голлох нөлөөтэй байв. Эдийн засгийн бүтцийн хувьд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний салбарын эзлэх хувийн жин багасаж, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин энэ үеүдэд нэмэгдэж байсан бол 2010 оноо хойш уул уурхайн салбарын хувийн жин нэмэгдэж эсрэгээрээ ХАА-н салбарын ДНБ-нд эзлэх хувь буурсаар байна. Үүний гол шалтгаан нь гадаад зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлт явагдаж хөрөнгө оруулагчдын сонирхлыг уул уурхайн салбар илүү татан, хөрөнгө оруулалт энэ салбарт түлхүү хийгдэж эхэлсэнтэй холбоотой юм. Ингэснээр эдийн засгийн хувьд тэлэлт бий болж орлогын бага түвшинтэй орноос дундаж орлоготой ангилалд шилжсэн нь зээл тусламжийн дүнг багасаж, гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нь эдийн засагт түлхүү байр суурийг эзлэх болсон.

Гадаад эдийн засгийн харилцааг илэрхийлдэг гол үзүүлэлт нь төлбөрийн тэнцэл юм. Төлбөрийн тэнцэл нь тайлант хугацаанд Монгол Улсын эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа,

үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалыг системчлэн нэгтгэсэн статистикийн тайлан гэж тодорхойлсон байдаг. Хэдийгээр эдгээр нь тухайн улсын хувьд гадаад эдийн засгийн харилцааг бүхэлд нь илэрхийлж байгаа боловч ямар улстай хэдий хэмжээний эдийн засгийн харилцаатай болохыг нарийвчлан харах боломжгүйгээр олон нийтэд тархаадаг. Тиймээс гадаад эдийн засгийн харилцаа сонгож авсан улстай ямар түвшинд хэрэгжиж байгааг тодорхойлоход нарийвчилсан статистик мэдээнүүд шаардлагатай юм.

Олон улсад хийгдсэн судалгаануудаас авч үзвэл (Fathimath Musthaq 2021) Аливаа улс нь глобал эдийн засгийн санхүүгийн харьяалалд нэгдэн орсноор ямар нэгэн улсын эдийн засгаас хамааралтай болдог гэжээ. Тэгвэл энэхүү хамаарал ямар хэлбэрээр илэрч болох талаар (Bassam Jouny 2017) Ливаны эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан 4 төрөлд хувааж авч үзсэн.

- Гадаад худалдааны хамааралтай байдал: Нийт худалдааны эргэлт болон ДНБ харьцааны индекс, Импорт болон ДНБ-ий харьцааны индекс, экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс, Гадаад худалдааны бүс нутгийн тархалтын үзүүлэлт
- Хүнсний хамааралтай байдлын үзүүлэлт: Хүнсний бараа бүтээгдэхүүний харьцааны индекс, Хүнсний бараа бүтээгдэхүүний зөрүүний индекс
- Санхүүгийн хамааралтай байдал: Өр болон ДНБ-ий харьцаа, Зээл төлөлтийн хуваарийн уян хатан байдлын үзүүлэлт
- Гадаадад амьдарч буй иргэдээс хамааралтай байдлын үзүүлэлт

Эдгээр 4 үзүүлэлт нь тухайн улсын гадаад эдийн засгаас хамааралтай байдлыг нэлээд сайн тодорхойлон харуулж чадаж байгаа ч энэ хамаарал бүхэлдээ ямар хэмжээнд байгааг нэгтгэсэн үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

Гүрж улсын ICC (The ICC Georgia 2023) байгууллагын хувьд гадаад эдийн засгийн хамааралтай байдлыг улс орон бүрээр ямар хэмжээнд хамаарч байгаагаар нь тодорхойлон гаргах аргачлалыг боловсруулан гаргасан. Уг аргачлалд импорт, экспорт, мөнгөн гуйвуулга буюу мөнгөний урсгал, ГШХО, аялал жуулчлалын орлого гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлсон байна. Уг тооцоогоор 2022 оны байдлаар Гүрж улс нь ЕХ-оос 21 хувь, ОХУ-аас 19 хувь, Туркээс 12 хувийн хамааралтай байгааг тооцон гаргасан байна.

Манай улсын хувьд өмнө нь дурдсанчлан зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн үеэс эдийн засгийн харилцааны гол түнш орон нь БНХАУ болон ОХУ байгаа бөгөөд үүнийг нарийвчлан тооцож цаашид эдийн засгийн талаар баримтлах бодлогодоо анхаарах шаардлагатай юм.

Судалгааны арга зүй, тоон өгөгдөл

Судалгааны арга зүйн хувьд тухайн улс гадаад эдийн засгийн харилцаанд орохдоо гадаад эдийн засгийг төлөөлөх үзүүлэлтүүдээс хэр хүчтэй хамаарч байгааг тодорхойлох хоёр аргыг ашиглалаа.

- Гадаад эдийн засгийн хамаарлын бүтэц
- Зах зээлийн төвлөрлийг тодорхойлох Herfindahl-Hirschman Index (ННН)

Гадаад эдийн засгийн хамаарлын бүтэц: Энэ арга зүй нь дараах алхмаар явагдана.

1. Тухайн улсын зүгээс гадаад эдийн засгийн харилцааг илэрхийлдэг үндсэн үзүүлэлтээ тоон утгаар тодорхойлно.
2. Тодорхойлсон үзүүлэлтүүдийн нийлбэр авна.
3. 1-р алхамд тодорхойлсон дүнг 2-р алхамд тодорхойлсон нийт дүнд эзлэх хувийн жинг олох замаар илэрхийлнэ.
Өөр нэг хувилбар нь 2-р алхамд тодорхойлсон дүнг нэрлэсэн ДНБ-д харьцуулах байдлаар мөн илэрхийлж болно.

Хэрэв 1-р алхамд дурдсан тухайн улсын гадаад харилцааг илэрхийлсэн үзүүлэлтийн мөнгөн дүнг x_i гэвэл гадаад эдийн засгийн хамаарлыг бүтцээр илэрхийлж болно.

$$FEDR_i = \frac{x_i}{\sum_{i=1}^n x_i} \times 100$$

Энд $FEDR_i$ нь гадаад эдийн засгийн харьцаа байна. Энэ харьцаа үзүүлэлт боломжит түвшинд ойролцоо байх нь гадаад эдийн засгийн хамаарлын зохистой харьцаа бүрдэнэ.

Зах зээлийн төвлөрлийг тодорхойлдог Herfindahl-Hirschman Index (ННН): Энэ арга зүйг дараах байдлаар тооцно.

1. Гадаад эдийн засгийн харилцааг илэрхийлсэн үзүүлэлтээ тодорхойлно.
2. Үзүүлэлтүүдээ нэмэх замаар нийт гадаад эдийн засгийн цар хүрээг илэрхийлсэн дүнг тодорхойлно.
3. 1-р алхамд тодорхойлсон үзүүлэлтээ 2-р алхамд тодорхойлсон дүнд харьцуулж хувийн жинг тодорхойлно.
4. 3-р алхамд дурдсан үзүүлэлтүүдийг квадрат зэрэгт дэвшүүлж нийлбэрийг авах замаар төвлөрлийг тодорхойлно.

Хэрэв 3-р алхамд тодорхойлсон хувийн жинг s_i гэвэл ННН-ийг дараах байдлаар тооцно.

$$NHI = \sum_{i=1}^n s_i^2$$

Энэ индекс нь тоон утгаар илэрхийлэгдэнэ.

Тоон өгөгдөл:

Тооцоонд гадаад эдийн засгийн харилцааг илэрхийлэх экспорт, импорт, мөнгөн гуйвуулга буюу мөнгөний урсгал, ГШХО, гадаад өрийн хэмжээг 2017-2023 оны хоорондох ҮСХ болон Монгол банкнаас гаргадаг статистик мэдээллээс авч ашиглав.

Монгол Улсын гадаад эдийн засгийн харилцааны нөхцөл байдал

Монгол Улсын гадаад эдийн засгийн харилцааны үндсэн сувгуудыг дээрх тоон өгөгдөлд дурдсан экспорт, импорт, мөнгөн гуйвуулга, ГШХО, гадаад өрийн хэмжээгээр тодорхойлон динамик өөрчлөлтийн талаар авч үзье.

Экспорт.

Эдийн засгийн өсөлтийг тодорхойлох үндсэн хүчин зүйл нь гадаад худалдаа тэр дундаа экспортын өсөлт байдаг. Манай улсын хувьд эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан экспортын тоо хэмжээ болон үнийн дүн аль аль нь өсөлттэй явж ирсэн. Гэсэн хэдий ч экспортын бараа бүтээгдэхүүний дийлэнх буюу 90 орчим хувь нь уул уурхай бүтээгдэхүүний экспорт болоод байгаа билээ. Манай улсын экспортын хэмжээ 2005-2023 оны хооронд 15 дахин нэмэгдэж 1.1 тэрбум доллароос 15.2 тэрбум доллар болж өсжээ. Хэдийгээр экспортын өсөлт сайн байгаа боловч нэг улсаас хамаарах хамаарал маш өндөр, 2023 оны байдлаар нийт экспортын 91.2 хувь нь зөвхөн БНХАУ-д ногдож байгаа бол бусад улсын тухайд 1 хувь хүрсэн улс байхгүй байна.

Экспортын өөрчлөлтийг харвал дэлхийн санхүүгийн хямралын улмаас 2009 онд экспорт 25.6 хувиар огцом буурч байсан бол дараагийн жилд нь эдийн засгийн нөхцөл байдал сэргэж эхэлснээр 54.3 хувиар өсжээ. Эдийн засгийн өсөлт 17 хувьтай гарсан 2011 онд экспорт мөн л 65.53 хувиар огцом өссөн. Өөрөөр хэлбэл 2009 оноос хойш хоёр жил дараалан экспорт 50-аас дээш хувьтай өссөн гэсэн үг юм. Эдийн засгийн өсөлт саармагжсан 2015, 2016 онуудад экспорт өмнөх 2014 оноос бага байсан боловч эдийн засаг харьцангуй тогтворжихын хэрээр экспорт нэмэгдэж байжээ.

Зураг 1. Монгол улсын экспорт, экспортын өөрчлөлт (тэрбум доллар, хувь)



Эх сурвалж: 1212.mn

Цар тахлын дараах үе буюу 2021 оноос экспортын дүн нэмэгдэж 2023 онд 15.2 тэрбум доллар болж түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Энэ идэвхжил нь уул уурхайн үнийн өөрчлөлттэй нягт холбоотой бөгөөд хэлбэлзэл маш өндөр байгаа нь экспорт огцом өсөлттэй байхаас илүү тогтвортой өсөлт чухал болохыг илэрхийлж байна.

Импорт

Дотооддоо үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал боловч тухайн улсад зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг гадаад улсаас худалдан авах замаар дотоодын хэрэгцээгээ хангадаг. Экспорттой адилаар импорт ч эдийн засгийн өсөлтийн үед нэмэгдэж, эдийн засгийн уналтын үед багасдаг байна. Импорт 2023 оны байдлаар 9.2 тэрбум доллар болж өмнөх оноос 6 хувиар нэмэгдсэн. Манай улсын импортын гол нэрийн бүтээгдэхүүн нь шатах, тослох материал, цахилгаан эрчим хүч болон машин техник, тоног төхөөрөмж байдаг. Улс орноор нь импортын бүтцийг харвал 2023 оны байдлаар 34.7 хувь нь БНХАУ-д, 25.8 хувь нь ОХУ-д, 7.7 хувь нь Япон улсад тус тус ногддог байна.

Зураг 2. Монгол улсын импорт, импортын өөрчлөлт
(тэрбум доллар, хувь)



Эх сурвалж: 1212.mn

Импортын хэмжээ 2005-2023 оны хооронд мөнгөн дүнгээр 1.2 тэрбум доллароос 9.2 тэрбум доллар болж 7.7 дахин нэмэгджээ. Экспортын өсөлтөөс импортын өсөлтийн хурд бага байгаа нь эдийн засаг талаасаа эерэг үзүүлэлт байж болох юм. Эдийн засаг хамгийн өндөр өсөлттэй байсан 2011 онд импорт хамгийн өндөр 106.2 хувийн өсөлт үзүүлж байв. Үүнээс хойш эдийн засгийн өсөлтийн хурд саарч импорт ч буурсан бөгөөд 2009 оны бууралтаас хойших хамгийн өндөр бууралт 2015 онд болсон. Энэ онд импорт 27.3 хувиар агшиж байжээ. Цар тахлын үед импорт 13.6 хувиар буурсан бол цар тахал намжсанаар эдийн засгийн өсөлттэй уялдан импорт нэмэгдсэн. Экспорт 2023 онд 21.1 хувь

өссөн бол импорт дөнгөж 6 хувь өссөн нь валютын орох урсгалд эерэг нөлөө үзүүлж, валютын албан ёсны нөөц нэмэгджээ.


Мөнгөн гуйвуулга.

Монгол Улс шилжилтийн эдийн засгийн хүнд үед иргэд гадаад улс орнуудад гарч ажиллах нь эрс нэмэгдсэн. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт тааруу, амьжиргааны нөхцөл хүнд үед иргэдийн өөрийн эх орон руу шилжүүлж байгаа мөнгөн гуйвуулга нь иргэдийн амьжиргааг тэтгэхээс гадна макро түвшинд хэрэглээг бий болгож тэр нь эдийн засгийн нөхцөл байдлыг дээрдүүлэхэд чухал нэмэр болж байв.

Хөгжиж байгаа орнуудын хувьд ажиллах хүчний гадагшлах урсгал өндөр, түүнийг дагаад мөнгөн шилжүүлэг өндөр байдаг. (ХНХЯ 2016)-ийн тайланд дурдсанаар “Дэлхийн хэмжээнд 2015 оны байдлаар мөнгөн гуйвуулгын хэмжээ 601 тэрбум доллароос давсан байна. Хамгийн их мөнгөн шилжүүлэг хүлээн авсан орнууд нь Энэтхэг, Хятад, Филиппин, Мексик, Франц байна”. Мөнгөн гуйвуулга нь нэг талаас эдийн засгийг дэмжих чухал хөшүүрэг болдог бол нөгөө талаар гадаад шилжих хөдөлгөөнийг бүртгэх үзүүлэлт болдог байна. (Б.Мөнхжаргал 2021) Гадаад шилжилт хөдөлгөөний үр нөлөөг хэмжихэд олон улсад ашигладаг нэг гол мэдээлэл бол шилжигчдийн хувийн гуйвуулга байдаг гэж дурджээ.

Мөнгөн шилжүүлгийг бүртгэлээр нарийн тодорхойлоход төвөгтэй байдаг бөгөөд Монгол банкны зүгээс уг бүртгэлийг банкны мэдээлэл дээр тулгуурлан бүртгэдэг. Энд зөвхөн бүртгэгдсэн албан ёсны мөнгөн гуйвуулгын дүнг авсан бөгөөд хувь хүмүүсийн бэлнээр илгээсэн мөнгөн гуйвуулга ороогүй. Бодит байдал дээр энд авч үзсэн дүнгээс мөнгөн гуйвуулга нь хамаагүй өндөр дүнтэй байх боломжтой юм.

Зураг 3. Мөнгөн гуйвуулга, өөрчлөлт (сая доллар, хувь)



Эх сурвалж: Монгол банк

Зургаас хамгийн өндөр мөнгөн гуйвуулга нь 2018 онд 259.4 сая доллар байсан бөгөөд өмнөх онтой харьцуулбал 23.2 хувиар өссөн дүн юм. Энэ хугацаанаас хойш тасралтгүй буурч байсан бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал сайжирч эхэлсэн 2021, 2022 онуудад ч үргэлжлүүлэн буурсан. Мөнгөн гуйвуулга нь 2022 онд хамгийн өндөр 39.5 хувиар буурч 119.5 сая долларт хүрчээ. Нийт гадаад эдийн засгийн дүнд мөнгөн гуйвуулга нь маш бага дүн эзэлж, эдийн засагт үзүүлэх нөлөө улам бүр багассаар байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт.

Манай улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг гадаад эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэг нь Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) юм. Манай улсад оруулж буй ГШХО нь эдийн засгийн өсөлтийг тэтгэх гол эх үүсвэр нь болдог.

Эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй ГШХО-ын нөлөөг судалсан маш их судалгааны ажлууд байдаг. Судалгааны ажлын үр дүнгүүд ч ялгаатай гарах тохиолдлууд байна. Олон улсад хийгдсэн судалгааны ажлуудаар ГШХО нь зарим улсад сөрөг нөлөөтэй, зарим улсад нөлөөгүй, зарим улсад эерэг нөлөөтэй гэж гарсан байдаг. Мөн улс орнуудын орлогын болон институтийн хүчин зүйлээс шалтгаалаад эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө нь ялгаатай болохыг (Tamar Baiashvili and Luca Gattini 2020)-д дурдсан байна. ГШХО нь эдийн засгийн өсөлттэй хамааралтай байж болох боловч, урт болон богино хугацаанд ялгаатай байдлаар нөлөөлдөг тухай Avisa Malik and Ash Narayan Sah (2024)-д дурджээ. Уг судалгааны ажлаар BRICS-ийн орнуудын ГШХО нь богино хугацаанд эдийн засгийн өсөлттэй хамааралтай боловч урт хугацаанд хамааралгүй болохыг BVAR загвар ашиглан тооцсон байна.

Манай улсын хувьд ГШХО нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй болохыг (Н.Батсайхан 2002), (D.Gan-Ochir & L.Davaajargal 2019), (Б.Энх-Амгалан болон Э.Төгөлдөр 2023) нарын судалгааны ажилд дурдсан байна.

Зураг 4. ГШХО-ын үлдэгдэл, өөрчлөлт (тэрбум доллар, хувь)



Эх сурвалж: Монгол банк


Монгол Улс 2009 оноос Оюутолгойн гэрээг байгуулснаар 2010 оноос ГШХО-ын хэмжээ огцом нэмэгдсэн. Хөрөнгө оруулалт 2011 онд 36.7 хувь өссөн нь дэлхийд хамгийн өндөр 17 хувийн өсөлттэй эдийн засаг болоход хүргэсэн юм. Үүнээс хойш хөрөнгө оруулалт мөнгөн дүнгээрээ нэмэгдэж байсан боловч 2015, 2016 онуудад Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалт саатсантай холбоотойгоор ГШХО-ын дүн 2016 онд огцом 27.1 хувиар буурсан байна. Харин 2017 оноос хөрөнгө оруулалт хийж эхэлснээр цаашид ГШХО-ын орох урсгал тасралтгүй нэмэгдэж 2023 оны эцэс гэхэд 30.6 тэрбум долларт хүрээд байна.

ГШХО-ын үлдэгдлийг салбараар авч үзвэл уул уурхайн салбар 74.4 хувь, худалдааны салбар 5.6 хувь, санхүүгийн салбар 5.5 хувь, барилгын салбар 2.8 хувь, үлдэх 11.7 хувийг бусад салбар эзэлж байгаа нь цаашид бодлогын түвшинд анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна.

Гадаад өрийн хэмжээ

Эдийн засгийн өсөлтийг хангахад гадаад улс, олон улсын байгууллагаас хөнгөлөлттэй болон арилжааны чанартай зээл авдаг бөгөөд энэ нь улс орнуудын гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлж байдаг. Гадаад өрийг дотор нь Засгийн газрын, Төв банкны, Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад), Бусад салбарууд, Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг гэсэн хэлбэрээр бүртгэн тооцоог гаргадаг. Манай улсын Засгийн газрын зээлийн дийлэнх нь төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулдаг.

Зураг 5. Гадаад өрийн хэмжээ, өөрчлөлт (тэрбум доллар, хувь)



Эх сурвалж: Монгол банк

Гадаадын өрийн хэмжээ 2017 оноос хойш жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2022 онд нэг удаа 1.4 хувиар буурч байжээ. Гэсэн хэдий боловч 2023 онд 3.7


хувиар нэмэгдэж 34.6 тэрбум долларт хүрээд байна. Эдийн засаг өсөж, ДНБ тэлэхтэй холбоотой гадаад өрийн хэмжээ өсөж болох ч тодорхой харьцааг тогтоож, уг харьцаанаас давахгүй байлгахад анхаарах шаардлагатай юм.

Гадаад эдийн засгаас хамаарах хамаарал, төвлөрлийн индексийн тооцоо

Эдийн засагт төвлөрлийг тодорхойлдог олон аргууд байдгаас энэ ажилд гадаад эдийн засгаас хамаарах хамаарлын харьцааг бүтцээр илэрхийлсэн арга болон төвлөрлийг илэрхийлдэг Herfindahl-Hirschman Index (HHI)-ийг тус тус ашиглалаа.

Гадаад эдийн засгийн хамаарлын бүтэц: Уг үзүүлэлтийг тооцоход USAID, EPRC-ээс хамтран боловсруулсан Economic Dependency Index-д тусгасан арга зүй болон ICC Georgia-аас гаргасан Foreign Economic Dependence Index тооцох арга зүйг ашиглав. Уг индексийн тооцоонд өмнө дурдсан 5 үзүүлэлт нь тус бүрдээ ойролцоо хувьтай байх тохиолдолд гадаад эдийн засгаас хамаарах хамаарал жигд байна гэж үздэг.

Зураг 6. Гадаад эдийн засгийн хамаарлын бүтэц



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Тооцоог 2017-2023 өгөгдөлд тулгуурлан он тус бүрээр хийж үзэхэд нийт гадаад эдийн засагт эзлэх гадаад өр 2017 оноос тасралтгүй буурч 2023 онд 38.57 хувьд хүрчээ.


Харин ГШХО-ын хувьд 32.03-аас нэмэгдсээр 2022 онд оргил үедээ 34.26 хувь хүрсэн ч, 2023 онд 34.13 хувь болж 0.13 нэгж хувиар буурсан байна.

Экспортын хувийн жин тасралтгүй нэмэгдэж 2023 оны байдлаар 16.94 хувьд хүрсэн бол, импортын хувийн жин мөн л өсөж 10.32 хувь хүрчээ. Харин

мөнгөн гуйвуулгын хувийн жин дөнгөж 0.04 хувь гарсан нь Зурагт тодорхой харагдах боломжгүй байна. Эндээс харвал гадаад эдийн засагт оролцох үзүүлэлт бүрийн оролцооны хувийн жин харилцан адилгүй зөрүү ихтэй байна. Энэ нь эргээд төвлөрөл өндөр байгааг илтгэж байна.

Төвлөрлийг илэрхийлэх ННІ: Дээрх гадаад эдийн засаг дахь үзүүлэлтүүдийн оролцооны ялгаатай байдалд үндэслэн эдгээрийг нэгтгэн нэг утгаар илэрхийлж, төвлөрөл байгаа эсэх, байвал ямар түвшинд байгааг ННІ-г ашиглан тодорхойлон харуулъя.

Зураг 7. Гадаад эдийн засгийн үзүүлэлтүүдийн төвлөрлийн ННІ



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

ННІ-ийн утгыг дараах байдлаар тайлбарладаг.

- 100-аас доош байгаа тохиолдолд огт төвлөрөлгүй, өрсөлдөөнтэй болохыг харуулж байна.
- 100-1500-ын хооронд байвал төвлөрөл багатай, өрсөлдөөн сайтай
- 1500-2500 онооны хооронд байвал төвлөрөлтэй, өрсөлдөөн багатай гэж үздэг.
- 2500-аас дээш бол маш өндөр төвлөрөлтэй, өрсөлдөөн байхгүй гэж үзнэ.

Манай тооцсон индексийн үр дүнг харвал бүх утгууд 2500-аас дээш буюу манай улсын гадаад эдийн засгийн төвлөрөл маш өндөр байна. Энэ нь төвлөрлийг бууруулах шаардлагатайг гэсэн үг юм. ННІ-ын утга 2023 онд 3046 гарсан нь өмнөх жилүүдээс буурсан дүн боловч цаашид бодлогын хүрээнд гадаад өр зээлийг багасгах, импортыг либералчлах, экспортыг нэмэгдүүлэх, ГШХО-ыг зохистой түвшинд барих шаардлагатайг илэрхийлж байна.

Дүгнэлт

Монгол улс жижиг нээлттэй эдийн засаг бүхий улсын хувьд эдийн засгийн үйл ажиллагааг тогтвортой хангахад экспорт, импорт, ГШХО, гадаад зээл, мөнгөн шилжүүлэг зэргээр дамжуулан гадаад эдийн засагтай аль болох нээлттэй харилцах шаардлагатай юм. Эдийн засгийн нөхцөл байдал цар тахлын үед нэлээд хумигдаж уналттай гарсан нь гадаад эдийн засгийн харилцаа хязгаарлагдмал байдалд ороход хүргэсэн. Цар тахлын үед экспорт, импорт өмнөх оноосоо буурсан явдал нь үүний нотолгоо юм.

Энэхүү судалгааны ажлаар манай улсын гадаад эдийн засгийн харилцааг төлөөлөх таван үзүүлэлтийг ашиглан гадаад эдийн засгаас хамаарах хамаарлын бүтцийг гаргаж, төвлөрлийг индекс ашиглан тодорхойлсон.

Экспорт цар тахлын дараах үе буюу 2021 оноос огцом нэмэгдэж 2023 онд 15.2 тэрбум доллар болж түүхэн дээд түвшиндөө хүрчээ. Энэ идэвхжил нь уул уурхайн үнийн өөрчлөлттэй нягт холбоотой бөгөөд хэлбэлзэл маш өндөр байгаа нь экспортын огцом өсөлтөөс илүү тогтвортой өсөлт чухал болохыг илэрхийлж байна.

Цар тахлын үед импорт 13.6 хувиар буурч байсан бол цар тахал намжсанаас шалтгаалан эдийн засаг тэлж, импорт нэмэгдсээр байна. Экспорт 2023 онд 21.1 хувиар өссөнтэй харьцуулахад импорт дөнгөж 6 хувиар өссөн нь валютын орох урсгалыг нэмэгдүүлж, валютын албан ёсны нөөц өсөхөд чухал нөлөө үзүүлжээ.

Мөнгөн гуйвуулга 2018 онд 259.4 сая доллар хүрсэн нь өмнөх онтой харьцуулбал 23.2 хувиар өссөн дүн юм. Энэ хугацаанаас хойш тасралтгүй буурсаар 2022 онд 119.5 сая долларт хүрсэн нь хамгийн өндөр дүнгээр буюу 39.5 хувь буурсан үзүүлэлт болжээ.

ГХШО-ын орох урсгал 2017 оноос тасралтгүй нэмэгдсээр 2023 оны эцэс гэхэд 30.6 тэрбум долларт хүрээд байна. ГШХО-ын үлдэгдлийг салбараар авч үзвэл уул уурхайн салбар 74.4 хувь, худалдааны салбар 5.6 хувь, санхүүгийн салбар 5.5 хувь, барилгын салбар 2.8 хувь, үлдэх 11.7 хувийг бусад салбар эзэлж байгаа нь цаашид бодлогын түвшинд анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна.

Гадаадын өрийн хэмжээ нь 2017 оноос хойш жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2022 онд л 1.4 хувиар буурч байжээ. Гэсэн хэдий боловч 2023 онд энэ дүн 3.7 хувиар нэмэгдэж 34.6 тэрбум долларт хүрээд байна. Эдийн засаг өсөж, ДНБ тэлэхтэй холбоотой гадаад өрийн хэмжээ өсөж болох ч харьцааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, уг харьцаанаас давахгүй байлгах шаардлагатай.

Гадаад эдийн засгийн хамаарлын бүтцийг 2023 оноор тооцож үзвэл Гадаад

өр 39 хувь, ГШХО 34 хувь, Экспорт 17 хувь, Импорт 10 хувь, Мөнгөн гуйвуулга 0.04 хувь тус тус байгаа бөгөөд тархалтын хувийг харвал ихээхэн хэлбэлзэлтэй байна.

Herfindahl-Hirschman Index-ээр 2500 гэсэн онооноос илүү гарвал төвлөрөл маш өндөр байгааг илэрхийлдэг. Гэтэл манай улсын гадаад эдийн засгийн төвлөрөл авч үзсэн бүх хугацаанд маш өндөр гарсан нь төвлөрлийг бууруулах шаардлагатай болохыг илтгэж байна. ННІ-ийн утга 2023 онд 3046 байгаа нь өмнөх жилүүдээсээ буурсан дүн боловч цаашид бодлогын хүрээнд гадаад өр зээлийг багасгах, импортыг либералчлах, экспортыг нэмэгдүүлэх, ГШХО-ыг зохистой түвшинд барих шаардлагатайг илэрхийлж байна.

Ашигласан материал

- Avisha Malik and Ash Narayan Sah (2024) “Does FDI Impact the Economic Growth of BRICS Economies? Evidence from Bayesian VAR” *Journal of Risk and Financial Management*, Vol17(1), 10
- Bassam Jouny (2017) “Economic Dependence”, *Republic Of Lebanon Ministry of Industry Research paper*
- D.Gan-Ochir & L.Davaajargal (2019) “External shocks and business cycle fluctuations in Mongolia: Evidence from a Large Bayesian VAR”, *International Economic Journal*, vol. 33(1), pp. 42-64
- Fathimath Musthaq (2021) Dependency in a financialized global economy *Review of African Political Economy* Vol. 48, Iss: 167, pp 15-31
- Tamar Baiashvili and Luca Gattini (2020) “Impact of FDI on economic growth: the role of country income levels and institutional strength” *European Investment Bank, working paper series*
- Н.Батсайхан (2002) “Гадаадын шууд хөрөнгө оруулалт”
- Б.Мөнхжаргал (2021) “Монгол Улс дахь гадаад шилжилт хөдөлгөөний өнөөгийн хандлага, төлөв байдал” *Монголын хүн амын сэтгүүл*, Vol 31, pp 25-41
- Б.Энх-Амгалан, Э.Төгөлдөр (2023) “Монгол Улсын эдийн загийн салбаруудын нэмэгдэл өртөгт нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээ” *Journal of Business Innovation* Vol9(4), pp 4-18 Сангийн яам Түүхэн замнал <https://rb.gy/765u8b>
- ХНХЯ, ХНХСИ (2016) “Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөний нөхцөл байдлын судалгаа” *Улаанбаатар*